

**ЭЗЭНТ ГҮРНИЙ ҮЕИЙН
ХРИСТ ИТГЭЛТ РАББАН САУМАГИЙН
ЕВРОП РУУ ХИЙСЭН АЯЛЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Г.ТҮМЭНБАЯР

ОРШИЛ

Марко Поло, Виллиам Рубрук, Плано де Карпини – эдгээр хүмүүсийг эзэнт гүрэн рүү айлчлан ирсэн Европын элч төлөөлөгчид; Жувейн, Рашид Аддин – эдгээр хүмүүс бол эзэнт гүрний түүхийг бичсэн Персийн түүхчид гэдгээр нь Монголчууд бид андахгүй болжээ.



Тэдний бичиж үлдээсэн аян замын тэмдэглэл, түүхэн шастирууд нь эдүгээ тэр үеийн түүхийн талаарх бидний ойлголтыг тэлж өгсөн үнэлж баршгүй түүхийн эх сурвалж болж, олон жил судлагдсаар байна. Тэдний бүтээлүүдийг Монгол хэлнээр буулгасан нь зөвхөн судлаач эрдэмтдийн дунд төдийгүй жирийн нэгэн уншигчид ч гэсэн танил болоход чухал үүрэг гүйцэтгэсэн нь нэн тодорхой хэрэг билээ.

Сүүлийн үед дундад үеийн Монголын түүхтэй холбоотой Латин, Армян, Турк, Хятад, Манж гэх мэт хэл дээрх эх сурвалжууд орчуулагдан, судалгааны эргэлтэд орсоор байна. Жишээлбэл, Армяны түүх Григор Агнерцийн “Нум сумтан ард түмний түүх,”¹ Спалато хотын архидиако́н Томасын латин хэл дээрх “*Historia Salonitana*” гэсэн эх сурвалжуудыг нэрлэж болох юм.² Монголчуудын байгуулсан эзэнт гүрний үеийн түүхтэй нэн холбоотой, тэр дундаа Ил хаадын

¹ Григор Агнерци, Нум сумтан ард түмний түүх, орч. Д.Баярсайхан, Д.Анхбаяр (Улаанбаатар: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, 2010)

² Б.Чинзориг. Спалато хотын Томас архидиако́ны *Historia Salonitana* хэмээх XIII зууны монголчуудын түүхтэй холбогдох нэгэн латин сурвалж. // *Historia Mongolarum*, Том. XII (Улаанбаатар: МУИС-НШУС, 2013), 48-115.

улс болон энэ үеийн Хриситгэлтнүүдийн талаарх мэдээллийг өгч чадах Сири хэл дээрх бүтээлүүд нэн цөөхөн. Одоогоор бидэнд мэдэгдэж байгаа нь Раббан Саума болон III Мар Ябаллах нарын аян замын тэмдэглэл, еврей түүхч Бар Хебрюсын (1225-86) “*Чуулганы цадиг*[христитгэлийн]” юм.³

Миний бие хоёр Монгол элчийн бичсэн аян замын тэмдэглэлийг Англи хэлнээс чадан ядан буулган орчуулж, зохих тайлбар зүүлтийг хийсэн бөлгөө. Энэхүү аяллын тэмдэглэлтэй танилцахын өмнө тухайн үеийн дэлхий дахины түүхэн нөхцөл байдлыг эхлээд танилцуулах нь зүйтэй санагдана. Учир нь тэд зүгээр нэг дурандаа аялсан жуулчид байсангүй. Харин тэд дорно дахины Христийн чуулганы тэргүүнүүд байсан төдийгүй Монголын их хаад болох Хубилай, Аргун нарын элч нар байсан билээ. Өөрөөр хэлбэл, тэд Монголын эзэнт гүрний гадаад улсууд руу болон шашинд хандаж байсан их хаадын улс төрийн бодлогын төлөөлөгчид байлаа. Тэдний аяллыг алдарт Британника нэвтэрхий тольд “Тэрээр Марко Пологийн өрнөөс дорно руу чиглэсэн аялалтай ач холбогдлоороо дүйцэхүйц аяллыг дорноос өрнө рүү хийснээртэй алдартай” гэж үнэлсэн байдаг билээ.⁴

Монголчуудыг ирэхээс өмнөх үеийн Европ

Энэ үеийн Европ дахиныг ойлгохын тулд юуны түрүүнд Христитгэлийн түүх хийгээд бүс нутгийн газарзүйн байрлалыг мэдэх зайлшгүй шаардлагатай билээ. Европ тивийнхэн 1054 онд Баруун Ромын Католик, Зүүний Ортодокс (Үнэн алдартан) чуулган гэсэн хоёр том хэсэгт салсан юм.⁵ Гэвч энэ хуваагдал нь Христийнхний гурав дахь том задрал байлаа.⁶ Христийнхний сүүлийн энэ том хуваагдлаар Ромын бишопт харъяалалтай Баруун Европын Католик, Константинопольд харъяалагдах Зүүн Европ Византийн Ортодокс гэж салангид хөгжиж эхэлжээ. Цаашид үүнээс улбаалан Дорнод буюу Зүүн Европынхныг Үнэн алдартнууд, Өрнөд Европыг Католикийнхан гэж оноон нэрлэх болсон түүхтэй.⁷

Өөр бас нэг санууштай түүхэн үзэгдэл болбоос Христийнхний зүгээс

³ Bar Hebraeus. *The Chronography of Gregory Abū'l-Faraj 1225–1286. The Son of Aaron, the Hebrew Physician Commonly Known as Bar Hebraeus*. Edited by Ernest A. Wallis Budge. London: Oxford University Press, 1932 (reprinted in Amsterdam: Philo Press, 1976).

⁴ Британника нэвтэрхий толь, Боть V, П-47-СА (Улаанбаатар: Непко, 2010), 2625.

⁵ Ромын пап Лео IX Константиноплийн патриарх Михаел Герулариусыг чуулганаас хөөсний хариуд Ромын папыг өөрийг нь эргүүлээд чуулганаас хөөжээ. Ингэж хоёр тал харилцан нэг нэгнийгээ хөөснөөр Европын чуулган баруун, зүүн гэж хуваагдсан түүхтэй.

⁶ Христийн Чуулганы анхны хуваагдлаар Ази тивийн буюу Ассири, Халдей, Сири, Армени, Перс Арабууд тусгаа хөгжөөд явжээ. Удаах хуваагдлаар Ромын Эзэнт гүрний нутаг дэвсгэрт байсан чуулгануудаас Дорны Христийн Чуулган гэж нэрлэгдсэн Африк болон Ойрх Дорнодын чуулганууд тусгаар хөгжиж эхлэв.

⁷ Протестантууд XVI зууны эхээр зөвхөн Баруун Европт бий болсон Ромын Католик сүмийн завхралыг эсэргүүцэн гарч ирсэн хөдөлгөөн болно.

Лалынхны түрэлтийн эсрэг хийсэн хэд хэдэн удаагийн аян дайнууд. Түүхнээ үүнийг “Загалмайтны аян дайн” гэж нэрлэдэг. 1095 онд Ромын пап II Урбан ба Византийн хаан I Алекс нарын эхлүүлсэн Загалмайтны аян дайн 1270 онд нийт найман удаагийн томоохон аян дайны эцэст, Католикуудын ялагдлаар дуусгавар болоод байлаа.⁸ Гэвч 1271-72 онд Английн хунтайж Едвардын дайныг ес дэх нь буюу сүүлчийн дайралт гэж үздэг ба үүнд Ил хаант улсын хаан Абагад Едвардын зүгээс элч илгээн “Монгол-Франк” нарын холбоог тогтоох гэж оролдсоныг онцлууштай. Лавтайяа Ил хаант улсын зүгээс загалмайтны ба лалын шашны хоорондын зөрчлийг ашиглан баруун Европтой холбоо тогтоох гэж байсан нь илт юм.⁹

Эзэнт гүрний үеийн Зүүн Европ

Кипчак, Унгар, Болгар, Литв, Польш, Орос, Армен, Гүрж эдгээр нь Христитгэлийн Үнэн алдартны итгэлтэй, Дорно Европын улсууд болно. Эдгээр улсууд нь Монголын эзэнт гүрэнтэй шууд болон дам байдлаар холбогдсон. “... Дорнод Европод Ижил мөрөн, Карпатын засвар газар найман сая, Гүржид таван сая... хүн оришин сууж байсан ажээ” гэсэн мэдээллээс үзвэл энэ бүс нутагт барагцаалбал 20 саяас дээш хүн оршиж байсан бололтой.¹⁰

Зэв, Сүбэдэй нарын удирдсан цэргийн хүчин 1220 онд Армян руу анх халдан довтолсоноор Дорно Европ дахь Монголчуудын эзэгнэл эхэлсэн билээ. Армяныг эзэлсэний дараа Гүржийг эзлэн авахад Желал-Ад-Дины оролцоо нэмэр болсон бололтой. Учир нь Желал-Ад-Дин Кавказад дайн өдөөж, Гүржийн хүчийг сулруулаад байжээ.¹¹ Христийн шашинт Кавказын улсууд тэр дундаа Армян, Гүрж, Кипчакуудыг эзлэх дайн 1236 он гэхэд бүрэн шийдэгдсэн байна.

Бат, Сүбэдэй нарын удирдсан дараагийн дайн 1236 онд Орос руу чиглэгджээ. Эхний ээлжинд 1236 онд Болгарыг, дараа нь 1237 онд Рязаны вант улсыг, 1238 онд Москва тэргүүтэй Оросын 14 хотуудыг эзэлжээ.¹² Энэ удаагийн байлдан дагуулалт 1241 онд Өгөдэй хааны үхлээс болж хойшлогдсон түүхтэй. 1241 онд Польшийн Силезийн тайж Хенрик II Пий-ээр командлуулсан Польш, Чех, Германчуудын нийлмэл арми, түүн дээр Пап ламын илгээсэн Тевтоны рыцариудаар дэмжүүлсэн

⁸ Роберт Д. Линдер, Чуулганы түүх, орч. Б.Нарантуяа (Улаанбаатар: БСТ, 2008), 11.

⁹ Д.Анхбаяр, Монголын Эл хаант улс (Улаанбаатар: ШУА-ын ТХ, 2006), 90.

¹⁰ Монгол Улсын Түүх, II боть (Улаанбаатар: ШУА-ын ТХ, 2004), 266.

¹¹ Монгол-Татаарууд Ази Европт, ред. С.Л.Тихвинский, орч. Шагдарын Сандаг [орос хэлнээс] (Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1984), 195.

¹² Монгол Улсын Түүх, II боть (Улаанбаатар: ШУА-ын ТХ, 2004), 161.

Европын нэгдсэн армийг Монголчуудбутниргэжээ.¹³ Уг дайны үр дүнд Бат хааны үндэслэсэн Сарайд нийслэлтэй Алтан Ордны улс Кипчакийн тал нутагт байгуулагдсан билээ.

Эзэнт гүрний үеийн Баруун Европ:

XI зуун гэхэд бүтэн гурван зууныг дамжсан “Престр Жон”-ын тухай цуурхал Загалмайтны дайнд урам хугарч, зориг тэвчээр нь алдарсан католик сүсэгт Европчуудын хувьд бараг сүүлчийн найдвар болоод байлаа. Хэрэдийн ван Тоорил, Шеба хатны үр, Этиопын хаадын нэг гэх мэтээр Престер Жон хэн байсан талаарх олон таамаглал байдаг боловч яг тэр хаан байсан гэх хэцүү. Энэ талаарх Хью Кемпийн дүгнэлтийг илүү бодитой гэж үзэж болохоор.

“Эцэст нь Престр Жоны захидлууд худал хуурмаг зүйл байсан гэдэг нь илрэв. Эдгээр захидал нь загалмайтны цэргүүд лалын сэргэн мандлыг бусниулж чадахгүй болсноос үүдэн гарсан хоосон, хардлага, мөрөөдлийн үр дагавар байжээ. Гэвч зарим зүйл нь үнэний хувьтай байлаа. Захидлуудыг үнэн бодитой оршин тогтнож байсан хаант улс болон тодорхой нэгэн хаанд тулгуурлан бичдэг байсан байж болох юм. Тэр хаан нь Христийн нестор итгэлийн хүн байсан байж ч болох билээ”¹⁴

Дундад Азийг хүйс тэмтрэх үед Европчуудын энэ таамаглал, найдвар бараг биелж байх шиг санагдаж байв. Тэд Монголчуудыг эхэндээ Престр Жон хунтайжийнхан байна гэж найдаж байсан боловч тун удалгүй зүүн Европыг хүйс тэмтэрсэн Батын цэргүүдийн дайралтаас энэ бүхэн нь худал болохыг ухаарч эхэлжээ.

Энэ үеийн баруун Европ ямаршуухан байдалтай байв? Энэ үеийн байдлыг илэрхийлсэн мэдээ занги Монгол хэл дээр хомс юм. IV Иннокент пап Ариун Ромын хаан II Фредрикээс улс төрийн эрхийг булаан, ариун чуулганаас хөөсөн байсан тул Европ даяарх улс төрийн ба шашны эрх мэдэл түүнд төвлөрч байлаа. Түүний энэ үйлдлээс болон угаас Европын хан, хунтайж нарын үе дамжсан улс

¹³ Легницийн тулалдаан (пол.*Bitwa pod Legnicą*, герм.*Schlacht von Liegnitz*) буюу Вальштадтын тулалдаан (герм.*Schlacht bei Wahlstatt*) бол Монголын Байдар, Кадан хэмээх хоёр жанжны 20000 цэрэг Польшийн II Хенрик вангийн голлон удирдсан Польш, Германы эвслийн 60000 цэргийг бут цохисон тулалдаан юм. Тулалдааны гол зорилго нь Бат хаан, Сүбэдэй нарын Унгарын IV Бела вангийн цэрэг болон Австрийн Темплирийн ордений хүчинтэй тулалдах явцад буюу (Мохигийн тулалдаан) баруун жигүүрээс хавсран цохигдох аюулыг зайлуулан сэргийлэх зорилгоор Польшийн нутагт цөмрөн орсонд байжээ. Энэхүү тулалдаан нь Европчуудад цэрэг-дайн, түүний номлолд хандах хандлагыг үндсээр өөрчилсөн том сургамж өгсөн гэж барууны цэргийн түүхчид үздэг байна. Эх сурвалж: http://mn.wikipedia.org/wiki/Легницийн_тулалдаан

¹⁴ Хью Кемп, Түүхийн балархай жимээр (Улаанбаатар: МТӨС, 2009), 47.

төрийн дотоод зөрчил хурцдаад байсан үеэр IV Иннокентийн санаачлагаар Вена хотноо 1245 онд Леоны Зөвлөлийг хуралдуулсан аж.¹⁵ Уг хуралдааны гол хэлэлцэх асуудал нь өдрөөс өдөрт бодит аюул болж байгаа Монголчуудтай хэрхэн харилцах асуудал байв. Европын хан, хунтайж нарын дотоод зөрчил, олон жилийн туршид хийсэн Загалмайтны аянд дайнд сульдсан байдал гээд дотоод хүчин зүйлээс шалтгаалан тэд илүү найрсаг бодлогоор Монголчуудтай харилцахаар тогтсон байна. Ингээд Монголчууд руу элч төлөөлөгчдийг ээлж дараалан илгээж эхэлсэн түүхтэй. “1245 онд Карпиний Жиованни, 1247 онд Ансельмын хийсэн аяллаас хойш зуугаад жилийн дотор элч нарын долоон багийг илгээжээ. Эдгээрийн хамгийн сүүлчийнх нь Мариноллын Иоханы аялал бөгөөд түүний энэ аялал 1346 онд дуусжээ. Тэдний зарим захидлын эх хувилбар одоо ч Ватиканы номын санд хадгалагдаж байдаг.”¹⁶ Эдгээр элчин төлөөлөгчдийн зорилго:

Нэгд, Монголчуудын талаарх тагнуулын мэдээлэл цуглуулах

Хоёрт, Монголчуудтай эвийн гэрээ тогтоон, улмаар Лалынхны эсрэг хамтран тэмцэх

Гуравт, Монголчуудыг Христ итгэлтэн болгож өөрчлөх гэсэн үндсэн гурван зорилгод зангилагдаж байсан нь илэрхий байдаг. Илгээснийхээ хувьд Монголчуудын нөхцөл байдлыг тандах нь тэдэнд үнэ цэнэтэй байсан бол, илгээгдсэн элчдийн хувьд шашин номоо дэлгэрүүлэхийг илүүд үзэж байсан нь тэдний үлдээсэн бичээс, захидлуудаас тодорхой харагддаг. Рубрук энэ тухай: “Гэлэн минь, би түүнийг [Мөнх хаан] христос шүтлэгтэн болохыг дуртайяа ятгана. Учир нь би, бүхэнд үүнийг номлох гэж ирсэн шүү дээ” гэж ил чөлөөтэй ярьж байснаас нь тодорхой харж болно.¹⁷

Эзэнт гүрнээс Европ руу явуулсан төрийн бодлого

Монголын хаадын зүгээс эзэн Чингисийн өвлүүлсэн “*дэлхийг нэг захиргаанд нэгтгэх бодлого*”-ыг тууштай баримталж байсан тул Европыг нэгэн цагт дайлаар мордох нь тодорхой байсан. Зөвхөн баруун Европоос элч төлөөлөгчөө илгээж байсан гэдэг нь үнэнд нийцэхгүй. Монголын хаадаас удахгүй эзлэгдэх нигууртай Европ руу элч нараа харилцан илгээж байсан нь маргашгүй үнэн юм. Тэдгээр элч нарыг илгээж байсан зорилгоос Монголын эзэнт гүрний бодлогын учиг тайлагдах

¹⁵ Мөн тэнд., 144-146.

¹⁶ Мөн тэнд., 146.

¹⁷ Жиованни Дель Плано Карпини, *Монголчуудын Түүх* ба Гильом Дэ Рубрук, *Дорно этгээдэд зорчсон минь*, ред. Ц. Шагдарсүрэн, орч. С. Туяа, С. Цолмон [орос хэлнээс] (Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1988), 160.

Pier Giorgio Borbone (éd.)

Un ambassadeur du Khan Argun en Occident

*Histoire de Mar Yahballaha III et de Rabban Sauma
(1281-1317)*



Traduction de l'italien
par Egly Alexandre

PEUPLES ET CULTURES
DE
L'ORIENT

L'Harmattan

нь тодорхой билээ. Тэдний нэг болбоос Хубилайгаас Ил хаан руу илгээгдсэн Марк буюу III Ябаллах ба Раббан Саума гэсэн Христитгэлт Монгол элч нар болой.¹⁸

Аргун их хааны зараалаар 1287 онд Раббан Саума, эрхүүд Сабаадины хамтаар Ромд очжээ. Тэр жил пап IV Онорус таалал төгссөн байсан тул Ромын Зөвлөлийнхөнтэй уулзаж, дараа нь Парис орон Францын хаан гоо Филиптэй уулзаад, цаашлаад Бордод Английн хаан I Эдуардтай учран, түүнд Ариун зоог хүртээсэн байна. Дараа жил нь (1288) шинэ пап IV Николастай Ромд очин уулзаад, тэнд бас Ариун зоог хүртээгээд нутаг буцсан түүхтэй.¹⁹ Түүнийг буцан ирэхэд Аргун хаан айлчлалынх нь үр

дүнд сэтгэл дүүрэн байж, ордны дэргэд мөргөлийн дуган барих онцгой эрхээр Саумаг шагнасан аж. Хожим нь Аргун ба I Эдуард нар Египет дэх Сельджукуудын эсрэг “Монгол-Франк”-ын холбоо тогтоохыг зорьж байсанд уг элчийн гавьяа оршиж байгаа нь илэрхий. Монголчуудын хувьд нэг бол Европыг эзлэх, эсвэл нэгэнт дайсагналцаад удаж буй лалынхны эсрэг тэмцэлдээ холбоотон болгохоор зорьж байсан нь тодорхой байдаг.

Элчээс гадна Монгол хаадын илгээсэн захидал сэлт эдүгээ буй. Түүний нэг бол яах аргагүй Плано Карпинаагаар дамжуулан Гүюг хаанаас Перс, Латин хэл дээр орчуулуулан бичүүлсэн захиа орно. Уг захиаг IV Иннокентэд илгээсэн. Уг захидлын агуулгыг үзвэл Монголын хаад Европ дахиныг тэр чигээр нь айлгасан, дарангуйлсан аястайгаар сүрдүүлээд зогсохгүй, шууд бууж өгөхийг тулгасан болохыг харж болно.²⁰ Уг захидлаас бид тэр үеийн Монголын эзэнт гүрний Баруун

¹⁸ Ассирийн Чуулганы патриарх 3-р Яахбаллах-ийн тамга. Тэрээр (1245-1317) Аргун хааны зараалаар Европ орж байсан, хожим нь Монголчуудын ноёрхлын үед энэ том Чуулганы тэргүүн Патриарх (1281-1307) болсон. Уг нэр нь Маркос, зарим нь түүнийг Уйгур, зарим нь Онгуд гаралтай гэсэн байдаг.

¹⁹ Хью Кемп, Түүхийн балархай жимээр (Улаанбаатар: МТӨС, 2009), 136-139.

²⁰ “Мөнх тэнгэрийн хүчинд. Их хаанаас Папт илгээсэн бичгийг сайтар уншиж ойлгогтун. Пап өөрийн биеэр бараалхахгаар ирвэл зохимой. Тэгвэл бид өөрийн засаг билгээ сонсгох болно.

Европ руу явуулсан бодлого, бусад улсууд руу явуулсан бодлогоос ялгарах зүйлгүй гэдгийг бэлхнээ харж болж байгаа юм.

II. САУМАГИЙН АЯЛЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Зохиогчийн тухай

РАББАН БАР САУМА нь 1220 оны үед Их Монгол улсын нутаг Жүндүд төржээ.²¹ Түүний эцэг эх нь Онгуд овгийн язгууртан, эрхүүд буюу христитгэлт хүмүүс байжээ. Тиймээс түүний нэрийнх утга нь “Мацагийн хүү.”²² Еврей түүхч Бар Хебрюс түүнийг Уйгур хүн байсан гэж тэмдэглэжээ.²³ Хорь орчим насандаа санваартан болж, “раббан” гэсэн цолыг авсан байна. Барагцаалбал 1260-аад оны үед өөрийн шавь болох хожим нь дорно зүгийн [Юань гүрний] чуулганы тэргүүн өргөмжлөгдөн Мар Яахб Аллах III гэсэн цолыг хүртсэн Маркын хамтаар Иерусалим руу даяанчлан явжээ.²⁴ Ингэхдээ Хубилай хааны мөнгөн гэрэгэг зүүн явж Юань, Цагадай, Хүлэгүгийн хаант улсуудын нутгаар дайрч Тангуд орон, Хотан, Кашагар, Талас, Сир Дария мөрөн, Хорозан [Афганистан], Марага [Азербайжан] Мосул [Ирак] нутгуудаар дайрч Анид [Армян] хүрч очжээ. Тэндээсээ цааш Иерусалимд хүрэх гэсэн авч Ил хаан ба лалынхны дайны улмаас очиж чадалгүй Багдад хотноо үлдсэн аж. Багдад хотноо тэднийг Дорнын чуулганы тэргүүн Мар Денха I найрсгаар хүлээн авч, төдөлгүй [1266] тэднийг Ил хаант улсын хаан Абага руу илгээжээ. Эндээс харвал тэр хоёр анхнаасаа Хубилай хааны элч нар байсан нь тодорхой

Мажар зэрэг Христосын шашинт улс оронд Чингис хаан элч томилон явуулж Мөнх тэнгэрийн зарлигийг дуулгах гэв. Гэтэл тэдгээр улс орны иргэд Мөнх тэнгэрийг үл тоомсорлож чиний хэлж буй тэдгээр иргэд чинь үймээн самуун дэгдээж манай элчийг балмад хэрцгийгээр алж хороов. Учир иймийн тулд сая Мөнх тэнгэрийн хүчинд тэдгээр улс орныг даран эрхшээв. Мөн үүний дотор зарим иргэд Мөнх тэнгэрийн хүчинд ивээгдэн эсэн мэд үлдэв. Эгэл жирийн хүн хэрхэн өрөөл бусдыг гэсгээн цээрлүүлж чадах билээ. Чи бас <би бол Христосын шашинтан. Би ертөнцийн эзнийг хайрлана. ... -ыг үзэн ядна> гэжээ. Ертөнцийн эзэн хүн төрөлхтнийг нүгэл гэмтэй төрүүлсэн мөртлөө бас энэрэн хайрлах сэтгэл байна гэгчийг чи яаж мэдсэн бэ? Энэ мэт өгүүлэгч хүн тэнгэр бурхныг хэрхэн таних билээ. Наран мандахаас наран жаргах хүртэлх дэлхий ертөнц Мөнх тэнгэрийн хүчинд ивээгдэж буй. Мөнх тэнгэрийн зарлигийг зөрчвөл хэн ч юу ч хийж бүтээж чадахгүй. Та нар одоо үнэн сэтгэлээсээ биднийг дагаж орогтун. Тэгвэл бид та нарыг өршөөн хайрлана. Хэрвээ та нар Мөнх тэнгэрийн зарлигийг сонсохгүй эсэргүүцэн тэмцвэл бидний өстөн дайсан болно. Үүнийг та бүхэн сайтар мэдэгтүн. Хэрвээ та нар ондоо санаа өвөрлөх юм бол түүнээс гарах үр дагаврыг Мөнх тэнгэр мэдмөй”

²¹ Одоогийн Бээжин хот.

²² Араб хэлээр “Бар” – хүү, “Саума” – мацаг гэсэн утгатай. “Раббан” гэдэг нь багш, сургагч гэсэн Еврей үг.

²³ Thomas Francis Carter, *The Invention of Printing in China and Its Spread Westward*, 2nd edition (New York: Ronald Press, 1995), 171.

²⁴ Christopher P. Atwood, “Yahbh-Allaha, Mar,” *Encyclopedia of Mongolia & the Mongol Empire* (Bloomington: Indiana University, 2004), 598.

байна. Тийм учраас Мар Денха I өөрийг нь дорнын тэргүүнээр батламжлуулах хүсэлтээ тэр хоёроор уламжлуулан Абага хаанд дуулгахаар явуулсан бөгөөд Маркыг Юань гүрний чуулганы тэргүүнээр өргөмжилжээ. Хожим тэднийг Мар Денха I Юань гүрэн рүү буцаан илгээх гэсэн боловч дотоодын үймээнээс болоод амжаагүй. Мар Денха I насан эцэслэсний дараа [1281] түүний орыг Марк буюу Мар Яахб Аллах III залгамжилсан юм.

Ийнхүү тэд Абага хаанд бараалхахаар Марагад очсон боловч хаан насан эцэслэж, орыг нь хүү Аргун эзэлсэн байлаа. Лалынхны эсрэг баруун Европтой эвсэхийн тулд 1287 онд Аргун хаан Раббан бар Саумаг элчээр илгээжээ. Энэ аяллаар явахдаа ямар газар орныг туулан Европын ямар эрх мэдэлтэн, санваартнуудтай учирч байсан талаар дээр өгүүлсэн, мөн цаашид орчуулгын тайлбар дээр дэлгэрэнгүй өгүүлэх тул ингэсгээд азная. Тэрээр Европоос буцан ирсэнээс хойш Багдад хотноо үлдсэн амьдралаа өнгөрөөж 1294 онд тэнгэрт хальжээ.

Гар бичмэл, эх хуулбар

Еврей гаралтай, түүхч, эмч, христитгэлийн онолч, дорнын чуулганы Иаковын урсгалын санваартан Бар Хебрюс “Чуулганы цадиг” бүтээлдээ их хаан Хубилайн зараалаар Иерусалимд эргэл мөргөл хийхээр даянчилсан хоёр эрхүүдийн тухай анх тэмдэглэн бичжээ.²⁵ Тэрээр цааш нь энэ хоёр уйгур санваартан Курдистанд хүрч очсон боловч дайн самууны улмаас Иерусалимд хүрэлгүй Марагад очин Мар Денха I дорнын чуулганы тэргүүнтэй уулзсан тухай, Мар Денха I тэдний нэг болох Маркыг Юань гүрний чуулганы тэргүүн гэж өргөмжлөн, Мар Яахб Аллах III гэсэн цолыг соёрхож, түүнийг үхсэний хойно [1281] орыг нь залгамжлан дорнын чуулган тэргүүн болсон тухай өгүүлжээ. Энэ чуулганы шинэ тэргүүн хэдий боловсролгүй ч зан байдал дөлгөөн, итгэлийн сайн гэрчлэлтэй, Иаковынхтай ойр нөхөрлөж байсныг бичиж үлдээжээ. Бар Хебрюс 1286 онд насан эцэслэсэн бөгөөд Мар Яахб Аллах III-ын талаар өөр зүйлийг өгүүлсэнгүй. Харин Марк буюу Мар Яахба Аллах III 1317 оныг хүртэл Ил хаадын улсын христийнхнийг тэргүүлсээр насыг элээжээ. Тэдний талаар Бар Хебрюсын энэ мэдээллээс өөр ямар ч мэдээлэлгүй байсаар 1887 оныг хүргэсэн байна.²⁶

Ингээд 1887 оны 3-р сард Халдейн нутгийн Лазар итгэлт Саломон гэгч бээр

²⁵ Bar Hebraeus. *The Chronography of Gregory Abû'l-Faraj 1225–1286. The Son of Aaron, the Hebrew Physician Commonly Known as Bar Hebraeus*. Edited by Ernest A. Wallis Budge. London: Oxford University Press, 1932 (reprinted in Amsterdam: Philo Press, 1976).

²⁶ Wallis Budge, *The Monks of Kublai Khan* (London: The Religious Tract Society, 1928) <http://www.aina.org/books/mokk/mokk.htm#fn2> [2015, 11-p cap]

нэгэн залуухан турк христэд итгэгчид хадгалагдаж буй эртний нэгэн бичвэрийн Сири хэл дээрх хуулбарыг гуйн аваад хуулбарлан авчээ.²⁷ Унштал энэ нь Бар Хебрюсын тэмдэглэн үлдээсэн өнөөх хоёр эрхүүдийн аян замын тэмдэглэл болохыг мэджээ. Саломон өөрийн хуулбарыг Эцэг Бедиандаа илгээж, цаадах нь дутууг нь гүйцээн, эргэлзээтэй газар орны нэрс, бусад үгсийн залруулга хийн, орхигдсон үгсийг нэмж, Сири судлаач Рубенс Дувалаар хянан тохиолдуулаад 1888 онд Парис хотод анх хэвлүүлсэн байна. Тэр жилийн 11-р сард Британы Музей Урмиа дахь Америк Миссионы пастор Ж.Х.Шеддээс Сири хэл дээрх далан хуудас бүхий хуулбарыг худалдан авчээ.²⁸ Хожим нь Бедиан зарим нэг хуулбаруудыг олж өмнөхтэйгөө тулган 1895 онд “*Histoire de May Jab Alaha, Patriarch, et de Raban Sauma*” гэсэн нэртэйгээр засан сайжруулж хэвлүүлэв. Бедиан сүүлд нэмсэн хуулбаруудаа Курдистаны Минганиш тосгоноос гаралтай, Текама дахь нестор чуулганы тэргүүн Раббан Ионанаас олж авсан байдаг. Ингэж Хубилайн элч нарын аян замын тэмдэглэл олдож, түүхийн судлалд хэрэглэдэх болсон юм.

Раббан бар Саума ба түүний шавь Маркын энэхүү аяны тэмдэглэл нь анхандаа Перс хэл дээр бичигджээ. Харамсалтай нь Перс хэлнээс хэн, хэзээ хураангуйлан орчуулсан нь тодорхойгүй. Ямартаа ч Сири хэл дээр орчуулагч нь Раббан бар Сауматай уулзаж учирч явсан хүн байж. Барагцаалбал XIV зууны эхэн хавьцаа орчуулсан бололтой.

Хуулбарын орчуулга ба судалсан байдал

Раббан бар Саумагийн бүтээлд онцгой анхаарлаа хандуулж, судалгаанд эргэлт буцалтгүй оруулагчдын эхнийх нь Х.Х.Халл юм.²⁹ “Америкийн Дорнын Нийгэмлэг”-ийн сэтгүүлд хэвлүүлсэн цуврал нийтлэлүүдийн араас Дувал, Лами, Ван Хоонахер, Нолдеке, Хилгенфелд, Баумстарк нарын судалгааны нийтлэлүүд уг сэдвийг хөнджээ.³⁰

²⁷ Лазарчууд нь зүүний чуулганы нэг салбар урсгал.

²⁸ Эдүгээ энэ Сири хуулбар нь Британы Музейд MS. is Oriental 3636 гэсэн данстайгаар хадгалагдаж байна.

²⁹ Н. Н. Hall, in the *Proceedings of the American Oriental Society*, vols. exxvi-cxxix(1885-89). Түүнд 1888 оны Сири хуулбар байсан бөгөөд зарим нэг хэсгийг нь Англи хэл рүү орчуулсан ч төдийлөн түгээгүй юм. Америк миссионерүүдийн орчуулга 1885-87 оны хооронд *Zahrir dhe Bahracst* гүүлд хэвлэгдсэн байдаг. Гэхдээ уг орчуулгыг Сири хэлнээс Курдистан дахь орчин үеийн Сири хэлний нэг салбар болох Фаллаехи хэл дээр хийсэн тул бас л олонд түгэх бололцоог олгоогүй ажээ.

³⁰ Duval (in the *Jour. Asiat.*, tome xiii, p. 313 ff.), Lamy (in the *Bulletin of the Belgian Academy*; tome xvii, p. 223); Van Hoonacker (in the *Museon*, tome viii); Noldeke (*Literarisches Centralblatt*, col. 842-44); Hilgenfeld, *Bemerkungen* (Jena, 1894); Baumstark in *Oriens Christianus*, tome i, p. 385.

Бедианы Сири хуулбарын анхны орчуулгыг Аббе Чабот франц хэлнээ хийж *Histoire de May Jabalaha III* гэсэн нэртэйгээр 1895 онд Парис хотод хэвлүүлжээ. Ингэхдээ Бедианы 1888 оны анхны хуулбарыг орчуулсан байна. Гэвч Чабот 1865 онд хэвлэгдсэн Марко Пологийн орчуулгыг ашиглан Монголын хаад, Ромын пап, Византи, Франц, Английн хаадын нэрсийн талаарх үнэ цэнэтэй тайлбар хийж өгсөн төдийгүй Мар Яахб Аллах III-аас Ромын пап Бенедикт XI-д 1308 онд илгээсэн захидлын Латин хуулбарыг хавсаргасан нь онцгой байв.

Англи хэл дээрх анхны орчуулгыг Ж.А. Монтгомери хийж, “Яабаллах III-ын Түүх” гэсэн нэртэйгээр 1927 онд Нью Йорк хотноо хэвлүүлсэн байдаг.³¹ Гэхдээ тэр Перс хэлнээс Сири хэл рүү орчуулсан орчуулагчийн залбирал ба удиртгалыг орхисон байдаг юм. Харин Англи хэл дээрх бүтэн орчуулгыг Воллис Баж хийн, “Хубилай хааны лам нар” гэсэн нэртэйгээр 1928 онд Лондон хотноо хэвлүүлсэн ажээ.³²

III. СИРИ ХУУЛБАРЫН ОРЧУУЛГА УДИРТГАЛ

Сири хэлнээс орчуулагчийн залбирал

Бидний Эзэн Есүс Христийн хүчээр эцгүүдийн Эцэг, Захирагч (Мара), хоньчдын Тэргүүн МАР ЯАХБ АЛЛАХ, Дорны Католикус буюу Патриарх, РАББАН САУМА, Дорно Түрэгийн тэргүүн зочлогчийн түүхийг би бичиж эхлэв. Өө, бидний Эзэн, надад туслаж, Таны өршөөл намайг үүнийг бичиж дуусгаг. Амен.

Сири хэлнээс орчуулагчийн оршил

Бурхан, ертөнцийн Эзэн, өршөөнгүй хийгээд нигүүлсэнгүй, Түүний дүүрэн нигүүлслээр бүх зүйл хэлбэржжээ. Үнэний мэдлэгт хийгээд сайн үйл хэрэгт хүмүүн төрөлхтөн төгс болохын учир, сайныг үйлдэгчийг замчлан, дээш өөд чиглүүлэхийн учир Тэр Өөрийн цор ганц Хүүг ертөнцөд буулгав. Тэр нь хүн төрхийг өмсөн өөрийн алдар сууг нуув, гэвч Тэр халхавч болох хүмүүн төрөхийн цаанаас Өөрийн гэрэл юүгээ цацраав. Тэр хэрцгий, гажиг, бүдүүлэг хуулиудыг цуцлаад, тэдгээрийн оронд сүнслэг, төгс, ариун дагшин тушаалуудаа соёрхжээ. Амьтнаар тахилчлахыг халаад оронд нь Өөрийн бие ба цусыг тахил болгосноор ертөнц Түүнийг мэдэх мэргэн ухаанаар бялхжээ. Амьдрал хайрлагч сайнмэдээгээ Өөрийн ариун шавь нараараа газар бүрт, дөрвөн зүгт түгээж бүх дэлхий даяар

³¹ Montgomery, James A, *History of Yaballaha III* (New York: Columbia University Press, 1927)

³² Budge, E. A. Wallis, *The Monks of Kublai Khan* (London: Religious Tract Society, 1928)

сургаалынхаа сайн үрийг Тэр цацжээ.Тийн ертөнцийн дөрвөн зүгийнхэн шавь нараар нь гэгээрээд, Үнэн алдарт Итгэл хийгээд Ариун Гурвалаар тэтгэгдээд, сайн үйл хэрэгт төгс болгогдон алдаршуулагдав.

Няцаагдашгүй, нөлөөлөгдөшгүй ҮГ, Хуулийг Зохиогч нь үүнийг тунхаглан сийлээд “Харагтан, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав”(Мат 28:20).Эхнээсээ шагналаас зуурчээ. Хуульгүйчүүд нь Бурханы хөвгүүд болж аажмаар үг нь үйл хэргээ гүйцэлдүүлэв. Энэтхэгчүүд, Хятадууд, газар газрын дорнын ард түмэн Эзэний эмээхүйн хазаар ногтонд номхорч, тэдний мэдрэмж, ойлголт Сүнсээр тослогджээ.Сүнсний хүч ба бэлэгт нийцэхгүй бодол ба үйлтэй зөв хандлага гэж үгүй. Юу хийсэн болоод Абрахамын үр удам Еврейчүүд Бурханы гэрийн дайсан болов? Юу хийсэн болоод Харьгнууд (Абрахамын үр биш) Сүнсийг хүлээн авч, Бурханы гэрийн гишүүд болсны учир зовох болов?

Эдүгээ Түрэгүүд Бурханы буулганд захирагдаж, бүх зүрхээрээ Эзэний үгэнд гүн суурилж, итгэн биширч байна.“Хэрэв хэн нэг нь Над дээр ирж, өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд, ах эгч дүүсээ төдийгүй өөрийн амийг хүртэл үл ойшоохгүй бол тэр Миний шавь байж чадахгүй. Загалмайгаа үүрэлгүй Намайг дагагч нь Миний шавь байж чадахгүй”(Лук 14:26-27).Энэхүү тушаалыг сонсмогц гайхан биширч, хоёр дайчин маань өөрсдийн хүсэл зориг орхин, эцэг эх, үр хүүхдийг үл ойшоон, тэдэнд байсан бүх эрх мэдлээсээ татгалзав. Шаламгай бүргэд мэтгэдзалуу насныхаа оюун ухаанаа сэргээж, өөрсдийн үнэн Найдварыг олж автал нөр их хөдөлмөрлөж, хичээнгүй амьдрав.Хичээнгүй хөдөлмөртөө таригч нь хүслэн болсон амтат жимсийг хоол хүнсээ болгон хүлээн авдаг билээ.

Чингээд тэдний эх нутаг, хэрхэн өсөж өндийсөн хийгээд хэрхэн учирцгааж, хэрхэн аж төрж байсан талаар нэг бүрчлэн өгүүлсүү. Ийн өгүүлэхдээ тэдний амьдарч байсан цаг үед юу болсон талаар, тэдэнд юу тохиолдсон зэргийг дүрслэн бичиглэв.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

РАББАН САУМАГИЙН ТҮҮХ

Нэгэн сүсэгт хүмүүн байсан ба тэрээр язгуур дээд угсаатай, Бурханаас эмээгч нэгэн байв. Ертөнцийн эд зүйлээр тэр элбэг баян байсан бөгөөд төрөхөөс авьяас бэлэг нь ундарсан нэгэн байлаа. Нэр алдартай овгийн, алдар суут гэр бүлд тэр төржээ. Түүний нэрийг ШИБА Саора гэдэг байв. Дорно зүгийн нийслэл хот болох ХАН БАЛИК хэмээх хотноо тэр амьдарч байжээ [Бээжин]. Хуулийн дагуу КЕЯАМТА хэмээх эмэгтэйтэй гэрлэжээ. Тэгээд тэд хамтдаа олон жил амьдарсан боловч тэдэнд үр заяасангүй. Удмыг нь залгах үр заяагаач гэж тэд байнга Түүнээс шалан гуйж, Бурханд тасралтгүй залбирсаар байв. Тийн агуу хайр энэрлээрээ тайвшруулагч Тэрээр тэдний хүсэлтийг хүлээн авч, тэднийг энэрчээ. Шаналсан зүрхний хүсэлтүүд, гуйлт залбиралдаа ёлогчдыг Тэр хүлээн авах хүсэлтэйн учир тэр ажгуу. “Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ” айлдсанаар Тэрээр итгэсэн бүрт найдвар хайрлав (Мат 7:8). Ингэхдээ зөв хандлагаар залбирагч эрэгтэй эмэгтэй хүмүүст хоёуланд нь үүнийгээ үзүүлэв. Харагтун, Халканагийн гэргий Ханна зөв хандлагаар залбирсанд хүлээн авагдав (1Ca 1:10), мөн Маноагийн эхнэр ч хүлээн авагдсанаар өрөөндөө тэнгэрэлчтэй учирсан бөлгөө (Шүү 13:2).

Чингээд Бурхан КЕЯАМТА дээр амьсгалсанд тэр хүү төрүүлж, тэд түүнийг САУМА гэж дуудах болов. Тэд агуу ихээр баярлаж, түүний төрсний учир хөршүүд, төрөл садангууд нь ихэд баярлалдав. Цаг нь болж хүү сургаалыг хүлээн авахуйц болоход тэд түүнийг эрхэм хүндэт багшид даатгалаа. Багшийнхаа зааснаар тэр сүмийн ухаанд хичээн суралцав. Тэгээд онгон охиныг түүнд богтлон сүйлэв. Тэр санваартны ёсыг сахиад санваартан болоод, дээр өгүүлсэн хотынхоо чуулганыг Сахин хамгаалагч болов. Тэр цэвэр ариун, төлөв амьдралаар замнаж, сүнслэг давуу чанарыг эзэмшихийн тулд зүтгэн, энэ бүхэнд нь төвөг учруулах алив дэлхийн юмстай тэмцэлдэв. Хорин насанд хүрэхэд түүний зүрхэнд нь тэнгэрлэг гал бадамлаж нүглийн хатгуурыг шатаахуйд, элдэв бузар, ялзралаас сүнсийг нь цэвэршүүлжээ. Юм бүхнээс илүүгээр Эзэнийг хайрлан, анжсан дээр гар тавьсан тул Түүний араас л мөшгөв (Лук 9:62). Ертөнцийн сүүдрээс тэрээр дайжин, хүслийг татагч бүхнээс татгалзах болов. Устах аливаа тансаг бүхнийг тэвчин, эрийг согтоогч амтат дарсыг тэвчжээ.

Энэ бүхнийг ажигласан түүний эцэг эхийг үлэмжийн зовлон эзэмдэж, хүү нь тэднээс салах болсноос гүн санаашралд автав. Тэд босоод, эмтэрсэн зүрхээр түүнд ирээд, энэ ертөнцийн бүхнийг амлан байж ийн хэлэв: “Хонгор хүү минь, юунд биднээсээ чи салан одох болов? Юунд биднийгээ шаналгана вэ? Юунд бидний энэллийг үл үзнэм? Одоо хэлээч! Бид хөрөнгөө хэнд өвлүүлэх вэ? Хэн бидний хүү билээ, санаач! Ажил хөдөлмөрийг шимийг хэн хүртэх ёстойг тунгаагаач! Үр минь, нэрийг минь хэн залгамжлах вэ? Үр минь, харь хүн мэт сэтгэл бодолдоо биднийгээ үл дурсана вэ?” Ийн уйлан байж түүнийг ятгаж, өөрсдийн харууслаараа түүнийг сэтгэлийг догдлуулжээ. Тэгээд тэр тэднийг сонсож, гаднаа тэдэнд аятай хандавч, дотроо тун аягүйцэв. Гурван жилийн турш биеэрээ эцэг эхээ асран тойлсон, тэр өөрийн хэргээс буцсангүй, өөрийн үйлийг үргэлжлүүлсээр байв.

Тэдний [эцэг эх] чармайлт тусыг эс олж, тэдний үгс Христийг хайрлах түүний хайртай үл тэнцэхийг мэдээд тэд түүнийг хүслээр нь орхив. Чингэхэд тэр өөрийн бүх эд хөрөнгөө хувааж, гоёл чимэг, өмсгөл зүүлтээ ядууст тарааж, санваартны орхимжийг өмсөөд, ширээт хамба [метрополитан] ариун, бишрэлт МАР ГИВАРГИС-аар үсээ хусуулжээ.

Тийнхүү ирж буй хаанчлалын найдвараар Эзэний усан үзмийн талбайд ажиллахаа ажлаа тэр эхлүүлсэн бөгөөд тэнгэрлэг газар дахь баялаг нь түүний ажлын хөлс нэг денар болов (Мат 20:1-16). Долоон жил сүмд суусны эцэст тэр хүний хөвгүүдээс салж, аглаг ганцаар амьдрахын тулд ууланд даянчлахаар шийджээ. Тийн тэр тэдний [эцэг эх] хотоос аян замдаа гарч зорьсон газраа хүрэв. Хүрсэн газарт нь агуй байх бөгөөд хажууд нь уулын горхи урсана. Тэндээ тэр амар тайван амьдарч, тэрхүү нутагт түүний тухай мэдээ түгсэнд Бурханд талархав. Идэр эрс түүний үгсийг сонсохоор цугларч, хүн бүр түүнийг хүндлэх болжээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ДОРНЫН КАТОЛИК БА ПАТРИАРХ МАР ЯАХБ АЛЛАХЫН ТҮҮХ

Урьдаас мэдэгч Бурханд бүх зүйл илэрхий бөлгөө. Хүний хөвгүүдийн аливаа сайн хийгээд саар бүхий л бодол санаа нь тэднийг эхийн хэвлийд бүрэлдэхээс ч өмнө Түүнд ил аж. Тийм ч учраас Тэрээр тэднийг зан чанарынх нь (хэрэв сайн байх аваас) дагуу сонгох ба зөв шударга хэмээж, хэрэв бусармаг муу байх аваас шийтгэн цээрлүүлдэг. Мосед ийн хэлсэн байдаг, “*Харагтун, би чамайг Фараонд Бурхан мэт өгч байна*” (Гэт 7:1). Мөн түүний сонголт нь Мосегийн сайн байдал

ба Фараоны зүрх сэтгэлийн хатуу байдлын улмаас болдог. Фараоныг төрөхөөс ч өмнө түүний хахир хатуу байдал(зүрх сэтгэлийн), гологдол нь Бурханд тодорхой байв. Учир нь Бурхан нэгэнтээ Иеремиад *“Эхийн хэвлийд чамайг бүрэлдүүлэхээсээ өмнө Би чамайг мэдсэн бөгөөд төрөхөөс чинь өмнө Би чамайг ариусгаж чамайг үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон томилсон”* гэжээ(Иер1:5). Түүнчлэн Паул *“Бурхан урьдаас мэдсэн Өөрийн ард түмнээ голоогүй”* гэсэн нь мэдээж тэдний сайн хүсэл, ариун бодол санааны улмаас ажээ(Ром11:2). Өдгөө, сонголтын тодорхой шинж чанар нь сонгогдсон хүнээс илэрхий бөгөөд тухайн хүн нигүүлсэлд зохистой гэдгийг илтгэх баттай гэрчлэл тодрон харагддаг. Оюун санаа нь гэгээрсэн нэгэн нь үүнийг ойлгож чадах атал ухаан балар нэгэн нь үүнийг үл ухаарна. Бидний ярих гэж байгаа хүн бол өөрийн дээд зэргийн сахилга бат (эсвэл өргөмжлөгдсөн амьдрал)-ын улмаас сонгогдсон тул бидэнд түүний сонголтыг тодорхойлон өгүүлэх, мөн энэ нь төгс төгөлдөр хүсэлд хэрхэн хувь нэмрээ оруулсаныг дүрслэн харуулах шаардлагатай юм.

Дорнын нэгэн улсын КАВШАН хотод Бурханы өргөөнд цаг ямагт үйлчилдэг, Түүний хуулийг чандлан сахигч, гэм зэмгүй, ариун, зөвт, итгэл бишрэлтэй нэгэн байжээ.[Кавшангийн хот буюу Кун-Чанг нь Бээжин болон Тангадын хооронд байрлах бөгөөд хуучин хотоос арван тав хоног аялах газар байв. Чабот үүнийг Шань-Си мужийн Хо-Чанг-фу хот гэж үзсэн]. БАНИЕЛ хэмээгч дөрвөн хүүтэй ахлагч[архдиакон]байжээ. Хамгийн бага хөвүүнийг [тэрээр манай Эзэний 1245 онд төржээ] нь МАРКОС [Марк] гэх агаад ах нараасаа илүүтэйгээр сүмийн боловсролд шимтсэн нэгэн байлаа.....[эх бичвэр энд гэмтэлтэй, эсвэл зарим үгийг орхигдуулсан байна] ах нар нь түүнийг үүнд болон өөр иймэрхүү асуудал дээр зэмлэн буруушаавч (эсв. ятган ухуулавч), энэ нь тэдэнд эрүүл ухаантай хүнтэй гэхээсээ хөшөөтэй ярьж буй мэт санагддаг байлаа. Хожим нь тэрээр олон байдлаар зовлон шаналал амссан ч замаасаа эргэж буцсангүй, мөн түүний оюун санаа нь эрэл хайгуулаа зогсоосонгүй. Харин ч эсрэгээрээ тэрээр зориг шулуудан арван таван хоногийн нөр их хөдөлмөрийн дараа РАББАН САУМА-гийн байсан газарт хүрч иржээ. Тэр өөрийг нь баяртайгаар хүлээн авсан РАББАН САУМА-гийн амар мэндийг эрэв. Маркийг амарч сэргэсний дараа РАББАН САУМА түүнээс *“Хүү минь чи хаанаас ирэв? Чи юунд энэ ууланд ирсэн юм бэ? Ахан дүүс тань аль хотод байна вэ? Эцэг тань хэн бэ, хэний хүү вэ?”* хэмээн асуув.

МАРК түүнд хариулж өгүүлсэн нь, *“Би Кавшангийн хотын Баниел хэмээгч ахлагчийн[архдиакон] хүү билээ, намайг Марк гэдэг.”* Раббан Саума түүнд *“Ийм*

их хүч хөдөлмөр гарган ядарч зүдрэн над руу ирсэний шалтгаан юу вэ?” МАРК “Би таны талаар сонссон учраас бүгдийг орхин таныг хайж ирлээ, хүслийг минь бүү хөсөрдүүлээч. Би санваартан (эсв. даянч) болохыг хүсэж байна” хэмээн түүнд хэлсэнд РАББАН САУМА түүнд “Өө дүү минь, энэ зам хэцүү байдаг. Настай туршлагатай санваартнууд ч хүнд хэцүү байдлыг арайхийн тэвчих атал би залуус болон хүүхдүүдийг энэ аянд хэрхэн зөвшөөрөх билээ?” гэж түүнд хэлэв. Мөн түүнийг эцэг эх рүүгээ буцан очих олон шалтгаан хэлж түүнээс гуйсан боловч МАРК татгалзсаар байсан учир РАББАН САУМА хүлээн зөвшөөрч, түүнийг заан сургав; мөн тэрбээр түүнийг ноосон хувцсаар хувцаслаж, даяанч амьдралд хөтчилжээ. Гурван жилийн дараа МАРК санваартны гоёл ч гэж хэлдэг үсээ хусуулах ёслолыг бишрэлт ширээт хамба МАР НЕСТОРИС-оор долоо хоногийн эхний буюу “руха параклита” гэх Ням гарагт [залбирал эхэлдэг] хүртжээ. Тэрээр даяанчийн хүнд хүчир ажил хөдөлмөрийг үйлдэн үдэш болтол өдөржингөө үргэлжлэх мацаг барилтыг сахидаг байв. Мөнэнэ ууланд [санваартнууд], цэвэр ариун байдлыг мөрдөн мөшгөж байсан ба тэд өөрсдийн сүнсээ даатгасан Бурханаасаа тайтгарлыг авч байлаа.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

РАББАН САУМА, РАББАН МАРК НАР ИЕРУСАЛИМ РУУ ОЧИХЫГ ХҮССЭН НЬ

Нэгэн өдөр тэд бясалган байхдаа хэлэв, “Энэ нутгийг орхин өрнө зүгт одох нь бидэнд нэн тустай билээ. Амиа өргөсөн ариун хүмүүсийн хийгээд католик Эцгүүдийн шарилд очин [тэднээр] адислагдсугай. Ертөнцийн Эзэн, Христ бидний амийг уртасган, нигүүлслээрээ тэтгэвээс бид Иерусалим хүрч чадна. Тийн бид гэмийн бүрэн уучлалыг хүртэж, нүглийн тэнэглэлээсээ хэлтрүүлэгдэнэ” Хэдийгээр РАББАН САУМА аялал хэр хүнд хүчир, зүдэргээтэй, аян замд тохиох аюул, харь газарт учрах зовлон их болохыг сануулан РАББАН МАРК-ыг хорьсонч, РАББАН МАРК аян замд гарахаар сэтгэл шулууджээ. Өрнө зүгт өөрт нь эрдэнэс нөөцлөгдсөн гэж түүнд итгүүлж, РАББАН САУМА-г үгсээрээ шахан, аян замд гарахаар түүнийг шавдуулав. Нөхөрлөлөөс нь хагацахвий, эсхүл хэн нэгэн нь хорон мууд автахвий гэдэгт санал нэгдэн, тэд босоод эд хогшлоо, өдөр бүр хэрэглэдэг бүхнээ ядууст тараагаад тэд аян замынхаа хүнсээ базаан, хот руу [Бээжин] хамтдаа өгслөө.

Тэнд тэднийг таних эрхүүдүүд тэдний зорилгыг мэдээд тэдний төлөвлөж

буйд юу учрахыг сануулахаархамтдаа цугларлаа.³³ Чингээд тэд өгүүлрүүн “Бэдэн аялагчид минь, тэр газар нутаг хэр хол гэдгийг мэдэхгүй гэж үү? Тэр газарт хүрэхийн эцэсгүй, олон замыг туулахыг та нар мартсан эсвэл үл хэрэгсэнэ үү? Юунд дуудагдсанаа гүйцээхийн тулд эндээ үлдэхтүн! Энэ нь *“Бурханы хаанчлал нь та нарын дунд байна”* гэсэн буй (Лук 17:21). Тэгэхүйд, РАББАН САУМА, РАББАН МАРК нар хариулав, “Ертөнцийг огоорон, даянчлан амьдраад он уджээ. Үүний тулд бид өөрсдийгөө үхсэн хүн мэт тооцдог. Хүнд хүчир нь биднийг сүрдээхгүй, айдас нь бидэнд саад болохгүй. Тиймд, Христийн хайрын учир бидний төлөө залбирч байхыг та нараас хүсье. Чингэвэл та нар эргэлзээг төрүүлэгч ертөнцөөс татгалзаж, Бурханд өөрсдийгөө даатгаваас бидний хүсэл биелэх буйзаа” [Тэгээд тэр хотын эрхүүдүүд], “Амар тайван явдаа” гэж хэлцгээв. Тэд бие биенээ үнсэн, гашуун нулимс унаган, уйтгарт үгсийг өгүүлэн, “Амар тайван явдаа. Та нарыг сахин харагч Эзэн маань та нартай хамт байг. Таалалдаа та нарыг Тэр таалж, та нарт туслах болтугай. Амен” гэв.

Чингээд РАББАН САУМ, РАББАН МАРК нар КАВШАН хотноо иржээ. Хоёр санваартныг ирсэнийг дуулсан хотынхон болон РАББАН МАРК-ын эцэг эх хөл хөөрцөгтэйгөөр учран, баяр бахдалтайгаар угтан авч, тэднийг сүмдээ оруулж гүн хүндэтгэлийг үзүүлэв. Тэд тэр хоёрын хааш аялж буйг мэдсэнч, түр саатах биз, РАББАН МАРК гэр бүлээ хайхрах биз хэмээн бодож байлаа. Төдөлгүй тэд Иерусалим руу, өрнөд рүү, хэрхэн шургуу аялан, хүнд бэрхийг туулан, зүдэн ядан явааг мэдэцгээв.

Хоёр санваартны ирсэн тухай мэдээ тэр хотын ноёд болох ХОНБОГА (нар шүтлэгтэн), ИБОГА (сар шүтлэгтэн) нарт болоод Хаадын хааны ач хөвүүн, ХУБИЛАЙ ХААНД сонсогдмогц, зарлага илгээн тэднийг ордондоо авчруулжээ. Тэднийг баяртайгаар, цээжинд орхилох хайр дүүрнээр угтан авчээ. Чингээд ноёд “биднээс дутаах вий” хэмээн бодсон тул ийн асуув “Юунд өөрсдийн нутгийг орхиод өрнө зүгт одох болов? Өрнөөс ирсэн бидний эцгүүд хийгээд санваартнууд хэр хүчир бэрхийг туулсаныг бид мэднэ. Тийм байхад бид юунд та нарыг явуулах билээ? РАББАН САУМА тэдэнд хариулан “Бид ертөнцийг огоорогсод. Хүний ертөнцөд амьдралч бидэнд амар тайван үгүй. Иймээс бидний авралын төлөө Өөрийгөө үхүүлсэн Христийг хайрлахын учир ертөнцийг огоорох нь бидэнд зөв юм. Ертөнцийн юм бүрийг бид ардаа орхив. Орхин явуулахгүй гэсэн та нарын хайр, биднийг тогтоох та нарын нигүүлсэл, биднийг тэтгэх та нарын өгөөмөр

³³ “Эрхүүд” гэдэг нь МЭ VII зуунаас XIV зуун хүртэл тал нутагт байсан Христэд итгэгчдийг нэрлэж байсан нэршил.

гарч тэр биднийг зогсоохгүй. *‘Учир нь хүн бүх ертөнцийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ’* хэмээн Эзэний үгийг дурсан санахад, бидний аялан явах нь туйлаас баяртай хэрэг болно (Мт 16:26). Бидний чин хүсэл болбоос эндээс явах, гэвч өөрсдийн ядралд, өдөр шөнөгүй та нарын хаанчлалын төлөө дурсан залбирах болно” гэв.

Тэр хотын ноёд өөрсдийнх нь үгс ямар ч тус болохгүйг мэдээд, тэднийг дахин хүчлэн ятгасангүй, харин унах адгуус, алт мөнгө, гоёл зүүлтийг бэлэг болгон соёрхов. Тэгэхэд хоёр санваартан “Эдгээр зүйлс бидэнд хэрэггүй. Юунд хэрэгтэй билээ? Эдгээр хүнд зүйлсийг бид хэрхэн тээж чадах билээ?” гэгцгээлээ. Хаад үүний хариу болгож “Аялал тань хэр удах хийгээд хэр зардал чирэгдэлтэй болохыг тануус мэдэхгүй. Харин бид мэдэх тул, зорьсон газраа очиж чадахгүй ч байж магад тул бүү гар хоосон яв гэж зөвлөе. Бидний бэлгүүдийг хүлээн ав. Эдгээр бэлгийг биднээс зээлсэн гээд (бидний итгэл) хүлээн авагтун! Хэрэгтэй учрал тохиолдвол хэрэглэ. Эсбөгөөс хэрэглэхгүй бол хадгалаад, эргэж эсэн мэнд ирвэл Эцгүүд (бишоп) болон санваартнуудад хувь болгон түгээ. Тэгвэл “... *та нарын элбэг дэлбэг байдал нь тэдний хэрэгцээг хангаснаар...*” гэсэнчлэн бид өрнө зүгийн Эцгүүдийн хайр энэрэлд баясах болно. (2Ко 8:14). Чингээд хоёр санваартан хаадууд үнэн зүрхнээсээ өгч буйг мэдээд бэлгийг хүлээн авчээ. Тийн тэд баяр гуниг дүүрэн нулимастайгаар салах ёсыг үйлдэцгээжээ.

Ашигласан ном зохиолууд

1. Британника нэвтэрхий толь, Боть V, П-47-СА. Улаанбаатар: Непко, 2010.
2. Анхбаяр, Д.Монголын Эл хаант улс. Улаанбаатар: ШУА-ын Түүхийн хүрээлэн, 2006.
3. Жиованни Дель Плано Карпини, *Монголчуудын Түүх* ба Гильом Дэ Рубрук, *Дорно этгээдэд зорчсон минь*, ред. Ц. Шагдарсүрэн, орч. С. Туяа, С. Цолмон [орос хэлнээс] (Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1988), 160.
4. Кемп, Хью. Түүхийн балархай жимээр. Улаанбаатар: МТӨС, 2009.
5. Линдер, Роберт Д. Чуулганы түүх. орч. Б.Нарантуяа. Улаанбаатар: БСТ, 2008.
6. Монгол-Татаарууд Ази Европт, ред. С.Л.Тихвинский, орч. Шагдарын Сандаг [орос хэлнээс] Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1984.
7. Монгол Улсын Түүх, II боть. Улаанбаатар: ШУА-ын ТХ, 2004.

8. Газрын зургийг: <http://mapcollection.wordpress.com/2012/06/27/the-mongol-empire/>-аас авлаа
9. Bar Hebraeus. *The Chronography of Gregory Abû 'l-Faraj 1225–1286. The Son of Aaron, the Hebrew Physician Commonly Known as Bar Hebraeus*. Edited by Ernest A. Wallis Budge. London: Oxford University Press, 1932 (reprinted in Amsterdam: Philo Press, 1976).
10. Mikko Vasko. “*The Image of the Mongols in Syriac Texts in the Late Thirteenth and Early Fourteenth Century*,” *Assyrian Academic Studies*.
11. Nicolle David, *The Mongol Warlords: Genghis khan, Kublai khan, Hulegu, Tamerlane*. London: Brockhaptan Press, 1998.
12. Pier Giorgio Borbone. “*Some Aspects of Turco-Mongol Christianity in the Light of Literary and Epigraphic Syriac Sources*,” *Assyrian Academic Studies*. Volume 19, no. 2, 2005.